



# МОНГОЛ УЛС БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТУШААЛ

2007 оны 11 дугаар  
сарын 14-ны өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот  
Утас: 322480  
Факс: 976-1-323158

Гадаадад суралцуулах тухай

"Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2000 оны 12 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. 1999 оны шилдэг оюутан Даваа овогтой Ганбаярыг АНУ-ын Калифорни мужын Сан Диего хотын Олон Улсын Менежментийн Их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар 2000-2001 оны хичээлийн жилээс эхлэн суралцуулж, сургалтын төлбөр, амьжиргааны тэтгэлэг олгосугай.

2. ОХУ-ын Москва хотын Дипломатын Академид олон улсын харилцааны чиглэлээр суралцаж буй Шовоохой овогтой Жаргалсайханд 2000-2001 оны хичээлийн жилээс эхлэн 2 жилийн амьжиргааны тэтгэлэг олгосугай.

3. ОХУ-ын ШУА-ийн Микробиологийн хүрээлэнгийн докторантурт суралцаж буй Амгаабазар овогтой Энхтуяагийн эрдэм шинжилгээний ажлын хамгаалалтын зардлыг зээлээр олгосугай.

4. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газрын орлогч дарга /Л.Баттулга/-д тус тус даалгасугай.

САЙД - г.  А.ЦАНЖИД

  
